



**HUNNU AIR**

Wings of Mongolia

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ЯМАНДТ

### ХҮННУ ЭЙР ХХК

Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол,  
Чингисийн өргөн чөлөө, Мөнх тауэр, 9-р давхар,  
Улаанбаатар 17030, Монгол Улс  
Утас: +976 70112179 Факс: +976-11-328025

2025. 04. 08 № А-25/153

Танай \_\_\_\_\_ -ны \_\_\_\_\_ -т

Г Санаал хүргүүлэх тухай

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь уул уурхайн салбарын дараагаар хөрөнгө оруулалт хамгийн ихээр татах боломжит салбар бөгөөд аялал жуулчлалын салбарын эрчимтэй сэргэлтийн хүрээнд агаарын тээвэр болон аялал жуулчлалын салбарын бие биесээ дэмжин ажиллах, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагаа, нислэгийн зардлыг бууруулах, татварын бодлогод дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа энэ үед “Нэмэгдсэн өртгийн албан татвар”-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болсон нь цаг үеэ олсон асуудал гэж талархан хүлээн авч байна.

Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд агаарын тээврийн үнэ тарифыг аль болох бага түвшинд барьж ажиллах нь хамгийн чухал бөгөөд гадаад, дотоод аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх, зорчигчийн гар дээр очиж байгаа онгоцны тийзний үнийг бодитоор бууруулах нэг арга зам нь НӨАТ-аас чөлөөлөх юм.

Хүннү Эйр ХХК-ийн зүгээс “Нэмэгдсэн өртгийн албан татвар”-ын тухай хуулийн төсөлд дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

#### Дараах заалтуудыг буцааж оруулах:

##### **13 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх**

13.1. Дараах барааг албан татвараас чөлөөлнө:

13.1.6. иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл;

Тайлбар: “Хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл” гэж Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцэр”-ийн хавсралтад заасан бүтээгдэхүүнийг ойлгоно.

#### Дараах заалтыг өөрчлөн найруулах

12.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан, импортолсон бараа, ажил, үйлчилгээнд 10 хувийн татвар ногдуулна.

12.2. Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд тэг "/0"/ хувийн татвар ногдуулна.

12.2.3. олон улсын болон орон нутгийн нислэгт үзүүлэх агаарын навигацийн үйлчилгээ, агаарын холгийн түрээсийн үйлчилгээ, зорчигч, ачаа, шуудангийн агаарын тээврийн үйлчилгээ;

**Хувийг:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн танаа

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**HUNNU AIR**

УЛААНБААТАР ХОТ  
99-5040333 да 5514339

П.МОНХЖАРГАЛ